



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 300

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ном болон элэгдлээрээ анхны өргөө нөхсөн, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 1,049,999.88 (нэг сая дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг наян найман мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 60,000.00 (жаран мянган) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал Г.Билгүүдэй нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан мэдээ, тайлангийн баталсан маягтаар ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
TYP ORLON ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

0000603

Тэрийн ёмчийн бодлого, зохицуулалтын
2019 оны 27 дугаар сарын 12-ны өдрийн
300 дугаар тогтоолын хавсралт



Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

| рөнгийн нэр | Хэмжих нэтж | Тоо хэмжээ | Ашиглалтад орсон огноо | Балансын | | Хууримтлагдсан элэгдэл | |
|-------------|-------------|------------|---------------------------|--|---|---------------------------|--|
| | | | | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | | |
| | | | | (төгрөг) | | | |
| наж | Ш | 1 | 1995.01.01 | 989,999.88 | 989,999.88 | 989,999.88 | |
| | Е | 20 | 1975.01.01 | 3,000.00 | 60,000.00 | - | |
| йт дүн | | 21 | | | 1,049,999.88 | 989,999.88 | |
| | | | | (нэг сая дөчин есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг наян найман мөнгө) | (есөн зуун наян есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг наян найман мөнгө) | (жаран | |